**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 05 өдөр Дугаар 90 Мандалговь

Өмч ашиглуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын эзэмшилд ашиглагдаж байгаа Хүүхэд залуучуудын ордны их, бага заалыг Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын мэдэлд ашиглуулсугай.

2.Хүүхэд залуучуудын ордны их, бага заалыг Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын үйл ажиллагаанд бүрэн ашиглуулахыг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар (С.Ганзориг)-т даалгасугай.

3.Хүүхэд залуучуудын ордны 410 м2 бүхий их, бага заалны ашиглалт, хадгалалт, бүрэн бүтэн байдал, урсгал засвар үйлчилгээг бүрэн хариуцан ажиллахыг Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр (А.Ууганбаяр)-т,тогтмол зардал (халаалт, цахилгаан, дулаан)-ыг хариуцан ажиллахыг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар (С.Ганзориг)-т тус тус даалгасугай.

4.Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын төлөвлөгөөт үйл ажиллагааг зохион байгуулахад их, бага заалыг саадгүйгээр ашиглуулж, хамтран ажиллахыг Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр (А.Ууганбаяр)-т даалгасугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ